



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 495

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 117,181,818.18 (нэг зуун арван долоон сая нэг зуун наян нэгэн мянга найман зуун арван найман төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий ашиглалтын хугацаа дууссан Ниссан Патрол Y-62 маркийн, 18-98 УНК улсын дугаартай автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, Хөвсгөл аймгийн өмчид (Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Засаг даргын Тамгын газарт) бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. “Эрдэнэс Монгол” төрийн өмчит хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл), Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Должинсорогдог, Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Амгаланбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

